Төсвийн хөрөнгөөр 74,103.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 623 дугаар тогтоолоор 1,005.0 мянган төгрөгийн хангамжийн материал, аймгийн ИТХ-ын XVI хуралдааны “Хөрөнгө акталж, данснаас хасах тухай” 16/49 тоот тогтоолоор 155.5 мянган төгрөгийн мотоциклийн сэлбэгийг буцаан орлого авсан, байгаль орчны яамнаас хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох” II,III шатны санхүүжилтээр олгосон 147,402.8 мянган төгрөгийн 4 улирлын ажлын хувцас, бараа материал, НИК ХХК-аас шатахууны картын урамшуулал 340.7 мянган төгрөгийн шатахууны орлого нийт 148,904.0 мянган бараа материалыг хүлээн авсан нь бараа материал дансны үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Нийт 25,152.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан. Нөөцийн бараа материалын дансны оны эхний үлдэгдэл 301,409.0 мянган төгрөг бөгөөд Өлзийт сумын ойн зурвасын ажил, Галуут сумын Өргөөт рашааны тохижилтын ажил, модны дуслуур, Шинэ суурьшлийн бүсийн мод үржүүлгийн ажлын хашаажуулалт, усалгааны систем, гүний худгийн цооног гэх ажлуудтай холбоотой бараа материалыг нөөцөөр бүртгэсэн байна. Тайланд онд аймгийн ИТХ-ын XIII хуралдааны “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 13/09 дугаар тогтоолоор 10,000.0 мянган төгрөгийн өртөгтэй Өргөөт рашааны тохижилтийг Галуут сумын ЗДТГ-т “Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай” 13/11 дугаар тоот тогтоолоор 84,050.0 мянган төгрөгийн шинэ суурьшлийн бүсийн мод үржүүлгийн усжуулалтын системтэй холбоотой шугам хоолой, холбох хэрэгсэл, гүний худгийн цооног зэргийг Баянхонгор сумын ЗДТГ-т шилжүүлсэн байна. Нөөцийн

бараанд бүртгэлтэй 122,387.0 мянган төгрөгийн өртөгтэй шинэ суурьшлийн бүсийн Мод үржүүлгийн талбайн хашаажуулалт, ойн байгууламжийг улсын комисс хүлээн аваагүй байгаа бөгөөд улсын комисс ажиллаж хүлээн авсан акт гаргасны дараагаар үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэхээр хүлээгдэж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,077,845.5 мянган төгрөг болж 13,830.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 440.0 мянган төгрөгөөр программ хангамж худалдан авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023.11.30-ны өдрийн " Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 623 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын газраас 34,523.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил шилжиж ирсэн, Биологийн олон янзын байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төслийн 2023.04.26-ны өдрийн " Өмч хөрөнгөд бүртгэх тухай" 41/23 тоот албан тоотоор 13,380.0 мянган төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор илэрсэн Баянхонгор аймгийн Засаг даргын 2023.03.19-ны өдрийн "Үзэсгэлэнт Баянхонгор-2 төсөл хэрэгжүүлэх тухай" А/199 дүгээр захирамжийн хүрээнд авсан 9,995.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Баянхонгор аймгийн орон нутгийн өмчийн газрын 2023.07.18-ны өдрийн "Хөрөнгө дахин үнэлэх тухай" А/231 тоот албан тоот, 2023.08.03-ны өдрийн "Хөрөнгө дахин үнэлэх зөвшөөрөл олгох тухай" А/244 тоот албан тоотоор хөрөнгийн дахин үнэлгээ хийж 48 нэр төрлийн хөрөнгийг өртгийг 47,408.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн үнэлж нийт 105,747.2 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023.10.11-ны өдрийн 16/49 тоот Хөрөнгө акталж, данснаас хасах тухай тогтоолоор 21 нэр төрлийн 36,991.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан бол, үлдэх өртөггүй цаашид ашиглах боломжтой 29 нэр төрлийн 54,925.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа, өртгийг шинэчлэн бүртгэж нийт үндсэн хөрөнгө 91,916.5 мянган төгрөгөөр буурсан байна. 2018 онд 1,336.5 мянган төгрөгөөр дахин үнэлгээ хийсэн мод үржүүлгийн хашааг данснаас хасаж 1,336.5 мянган төгрөгөөр дахин үнэлгээний нэмэгдэл данс буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,539,850.0 мянган төгрөг болж 260,541.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан үр дүн 260,541.7 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 991,082.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,500.0 мянган төгрөг, нийт зарлагыг 994,582.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 80,783.9 мянган төгрөгөөр бууруулж 913,798.6 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн хуваарьт 2023 оны 07 сард тодотгол хийж

254,854.4 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны зардлыг нэмж тодотгосон ба 253,854.4 мянган төгрөгийн зардлыг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг өөрийн орлогоос санхүүжүүлэхээр батлагдсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 1,120,111.6 мянган төгрөг, өөрийн орлого 350.0 мянган төгрөг нийт 1,120,461.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 970,362.3 мянган төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд 145,208.0 мянган төгрөгийг зарцуулж, 4,891.3 мянган төгрөгийг орон төсөвт төвлөрүүлсэн байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд 150,500.0 мянган төгрөг төсөвлөж, засаг даргын А/374, А/72, А/135, А/331, А/470 дугаар захирамжуудаар усны тоо бүртгэлийг зохион байгуулах ажилд 20,000.0 мянган төгрөг, усны сан бүхий газар усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хамгаалалтын зураглал хийж баталгаажуулах ажилд 10,000.0 мянган төгрөг, усны нөөцийн хомстол бохирдлоос хамгаалах, усны зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулахад 5,000.0 мянган төгрөг, бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын талуудын оролцооны зөвлөл, Орог нуур Түйн голын сав газрын талуудын оролцооны зөвлөлийн хурлыг зохион байгуулж, үйл ажиллагааг дэмжих зардалд 10,000.0 мянган төгрөг, Түйн гол түүний цутгал голууд болон Орог нууранд биологийн төрөл зүйлийн судалгаа хийхэд 10,500.0 мянган төгрөг, ус ашиглагч томоохон аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтанд хяналт тавих ажилд 5,000.0 мянган төгрөг, нийт 6 ажлын 60,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанд шилжүүлж, 50,000.0 мянган төгрөгийн өртөгтэй "Аймгийн хэмжээнд ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах" ажлын тендер сонгон шалгаруулалтаар Агнуур судлалын нийгэмлэг ТББ-тай, 40,000.0 мянган төгрөгийн өртөгтэй "Галуут сумын 2-р багийн нутагт газар доорх усны мониторинг хяналт шинжилгээний цэгийг тохижуулах ажил"-ын сонгон шалгаруулалтаар Гранд Холдинг ХХК-тай тус тус гэрээ байгуулж нийт 145,208.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,115,570.3 мянган төгрөг буюу 99.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Байр ашиглалттай холбоотой зардлыг 190.7 мянган төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 5,301.6 мянган төгрөгөөр, нийт батлагдсан төсвийг нийт 5,541.3 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71413 Байгаль орчныг хамгаалан, нөхөн сэргээх	1,121,111,600.00	1,115,570,313.70	5,541,286.30	99.5%
2	80101 Үндсэн үйл ажиллагаа	936,142,700.00	935,937,679.70	205,020.30	100.0%
3	80219 Харуул хамгаалалтын зардал	7,673,000.00	7,668,934.00	4,066.00	99.9%
4	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	26,795,900.00	26,755,700.00	40,200.00	99.8%
5	81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	150,500,000.00	145,208,000.00	5,292,000.00	96.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ойн газрын даргын А/81 дүгээр тушаалаар Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний бүсийн зөвлөгөөн зохион байгуулах зардлын санхүүжилт 9,615.0 мянган төгрөг, Байгаль орчны аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн даргын “Хөрөнгө гаргах, гэрээ байгуулах” тухай А/229 дугаар тушаалаар Заг Байдрагийн Хүрэн бэлчирт Монгол туургатны Харвуул их наадам зохион байгуулах зардлын санхүүжилт 20,000.0 мянган төгрөг, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын “Тусгай зориулалтаар агнах ан амьтны тоо хэмжээ, хуваарь батлах” А/215 дугаар тушаалын дагуу нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулж 285,670.0 мянган төгрөг, шонхорын хураамжийн орлого, 179,011.5 мянган төгрөг нийт 494,296.5 мянган төгрөгийн орлого орсныг холбогдох шийдвэрийн дагуу зарцуулсан байна. Тэрбум мод зөвлөгөөний зардалд 9,615.0 мянган төгрөг, Монгол туургатны Харвуул их наадамд 20,000.0 мянган төгрөг, Байгаль орчны уур амьсгалын санд 142,835.0 мянган төгрөг, үнэт цаас, гэрчилгээний төлбөрт 487.5 мянган төгрөг, шонхорын улсын тэмдэгтийн хураамжинд 187,900.0 мянган төгрөг зарцуулж, 133,459.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь 2023 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 179,998.6 мянган төгрөгөөр батласан бөгөөд 119,498.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ажилд тендер сонгон шалгаруулалт зарлан шалгарсан байгууллагуудтай гэрээ хийж, гэрээг дүгнэсэн байна. 60,500.0 мянган төгрөгийг 6 ажлыг шууд гэрээ байгуулан гэрээг дүгнэж ажилласан байна. Түлш халаалтын зардалд нийт 17,520.8 мянга, гэрэл цахилгааны зардалд 3,342.0 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 2,000.0 мянган төгрөг, шатахууны зардалд 10,250.0 мянган төгрөг батлагдсанаас РМВ ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээ, Чандмань Баянхонгор ХХК-тай цэвэр бохир усаар хангах гэрээ, НИК ХХК-тай газрын тосны бүтээгдэхүүн зээлээр нийлүүлэх гэрээ, харилцагч байгууллагуудтай бараа ажил үйлчилгээ худалдах, худалдан авах гэрээ, ажил үйлчилгээ нийлүүлэх нийт 24 гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Байгаль орчин аялал, жуулчлалын газрын 2023 оны 12

дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Байгаль орчин аялал, жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 478 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардал 823,878.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,358.2 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,268.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь батлагдсан төсвийг нийт 5,541.3 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 12.1 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 176.0 мянган төгрөгөөр хэмнэж төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн алдаа зөрчил байхгүй.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны хяналтаар зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж аудитаар 11,308.6 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 10,168.6 төгрөгийн 1 зөвлөмж, 390.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 750.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосныг 100% хэрэгжүүлж, биелэгдсэн талаар тус байгууллагаас 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 181 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	750.0	2	750.0	100%
Албан шаардлага	1	390.0	1	390.0	100%
Зөвлөмж	1	10,168.6	1	10,168.6	100%
Нийт дүн	4	11,308.6	4	11,308.6	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,698.7 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс төлбөр барагдуулах 1,899.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчил арилгах, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,799.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитын явцад төлбөрийн акт тогтоох нөхцөл байдал илрээгүй.

5.2 Албан шаардлага

1.Илрүүлэлт: “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох” хөтөлбөрийн II,III шатны санхүүжилтээр үнэ төлбөргүй олгосон ажлын хувцсыг Улаанбаатар хотоос авчрахын тулд нэр бүхий 24 ажилчнаас тус бүр 75.0

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мянган төгрөгийг хураан авч зарцуулсан, зарим ажилчдад ажлын хувцсыг олгоогүй байна.

. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.4 дэх заалт “Хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд цалин хөлснөөс суутгал хийхийг хориглоно” Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдаас хуулийн тогтоомжид зааснаас бусдаар мөнгө хураахыг зогсоох, олгоогүй ажлын хувцасыг ажилчдад бүрэн олгох албан шаардлагыг хүргүүлэв.

2.Илрүүлэлт: Монгол туургатны Харвуул их наадмын үеэр хандиваар ирсэн био 00 болон бусад хөрөнгүүдийг хөрөнгөд орлого аваагүй, богино долгионы станцыг Биеийн тамирын спортын газарт хүлээлгэн өгөөгүй байна.

. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Хандиваар ирсэн хөрөнгүүдийг хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэх, богино долгионы станцуудыг зохих байгууллагат хүлээлгэн өгч зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.Илрүүлэлт: Аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Ц.Азжаргалд 2023.01.11-ны өдрийн Б/08 тоот тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг хавсран гүйцэтгүүлж 40%-ийн нэмэгдэл олгох тушаал гаргаж нэмэгдэл олгож байгаад 2023.06.28-ны өдрийн Б/35 тушаалаар жинхэлж, хавсарсан тушаалыг хүчингүй болгоогүй байхад 7 дугаар сараас хойш ажил хавсарсан нэмэгдлийг олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь “Ажил олгогч нь ажилтантай тохиролцооноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно. Ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно” заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил хавсарсны нэмэгдлийг нөхөн олгох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж²

Зөвлөмж байхгүй.

² Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажил хавсарсан тушаал хүчингүй болоогүй байхад 7 дугаар сараас хойш нэмэгдлийг олгоогүй.	1	1,899.7			1	1,899.7		
Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох" II,III шатны санхүүжилтээр үнэ төлбөргүй олгосон ажлын хувцсыг Улаанбаатар хотоос авчрахын тулд нэр бүхий 24 ажилчнаас тус бүр 75.0 мянган төгрөгийг хураан авч зарцуулсан, зарим ажилчдад ажлын хувцсыг олгоогүй	1	1,799.0			1	1,799.0		
Монгол туургатны Харвуул их наадмын үеэр хандиваар ирсэн био 00 болон бусад хөрөнгүүдийг хөрөнгөд орлого аваагүй, богино долгионы станцуудыг Биеийн тамирын спортын газар хүлээлгэн өгөөгүй байна.	1	0			1	0		
Нийт дүн	3	3,698.7			3	3,698.7		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
		0				0		
Дүн		0				0		



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 207/А0571206/БНА-2024/
192/НА-СТА-ТМЗ/

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Ц.Азжаргалд даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн Б/08 тоот тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг хавсран гүйцэтгүүлж 40%-ийн нэмэгдэл олгох тушаал гарган нэмэгдэл олгож байгаад даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Б/35 тушаалаар жинхэлж, хавсарсан тушаалыг хүчингүй болгоогүй байхад 7 дугаар сараас хойш ажил хавсарсан нэмэгдлийг олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно. Ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн

5040626

алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал " гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил хавсарсан нэмэгдэл 1,899,676 (нэг сая найман зуун ерэн есөн мянга зургаан зуун далан зургаа) төгрөгийг нөхөн олгох²

2. Зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2024 оны 06 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Байгаль орчин аялал, жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганзориг, нягтлан бодогч Л.Доржханд нарт хариуцуулав.³

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН¹:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Б.НАРАНЦЭЦЭГ



¹ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 203/А0571206/БНА-2024/
192/НА-СТН-ТШС)

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох” II,III шатны санхүүжилтээр үнэ төлбөргүй олгосон ажлын хувцсыг Улаанбаатар хотоос авчрахын тулд нэр бүхий 24 ажилчнаас тус бүр 75.0 мянган төгрөгийг хураан авч зарцуулсан

2. Төслийн хүрээнд үнэ төлбөргүй олгосон ажлын хувцсыг зарим ажилчдад олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.4 дэх заалт “Хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд цалин хөлснөөс суутгал хийхийг хориглоно” Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1

5040614

дэх “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажилчдаас хуулийн тогтоомжид зааснаас бусдаар мөнгө хураахыг таслан зогсоох, олгоогүй ажлын хувцсыг ажилчдад бүрэн олгох зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх⁴.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин аялал, жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганзориг, нягтлан бодогч Л.Доржханд нарт даалгав⁵.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁶:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Б.НАРАНЦЭЦЭГ



⁴ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

⁵ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

⁶ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

1

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 204 /АОСЗ/2026 /БНА-2024/
149 /НА-СТА-ТМС/

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол туургатны Харвуул их наадмын үеэр хандиваар ирсэн био 00 болон бусад хөрөнгүүдийг орлого аваагүй, богино долгионы станцуудыг Биеийн тамирын спортын газар хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040618

1. Хандиваар ирсэн хөрөнгүүдийг бүртгэн авч, санхүүгийн тайланд орлого авах, богино долгионы станцыг Биеийн тамир спортын газарт хүлээлгэн өгч зөрчлийг арилган, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганзориг, нягтлан бодогч Л.Доржханд нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Б.НАРАНЦЭЦЭГ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно